



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бигэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/121/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр
	Утас: 70483413      Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a>
	Аудитын менежер:      Д.Эрдэнэчимэг
	Утас: 70484055      Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a>
	Аудитор:      П. Ганцолмон
	Утас: 70157405      Цахим хаяг: <a href="mailto:uliastaivanaudit@gmail.com">uliastaivanaudit@gmail.com</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
4.1 Залруулсан алдаа.....	14
4.2 Төлбөрийн акт.....	14
4.3 Албан шаардлага.....	14
4.4 Зөвлөмж.....	15
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25 № 128

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Бигэр сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Бигэр сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

07120302

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	48,771,104.87	55,335,842.44
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	0.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	0.00
31210	Төгрөг	-	0.00
31211	Төрийн сангийн харилцах	-	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	48,771,104.87	55,335,842.44
35100	Түүхий эд материал	21,808,562.87	27,281,289.44
35110	Тусгай зориулалттай материал	21,669,562.87	26,904,289.44
35130	Эм боох материал	139,000.00	377,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	106,000.00	150,200.00
35400	Хангамжийн материал	26,856,542.00	27,904,353.00
35410	Бичиг хэргийн материал	34,500.00	-
35420	Аж ахуйн материал	21,077,042.00	20,907,564.00
35440	Түлш, шатах тослох материал	5,745,000.00	2,626,800.00
35450	Барилгын засварын материал	-	1,157,000.00
35460	Хүнсний материал	0.00	3,212,989.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	775,266,917.32	751,025,074.28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	775,266,917.32	751,025,074.28
39200	Биет хөрөнгө	759,952,917.32	735,771,074.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	708,411,724.07	708,411,724.07
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(32,947,628.40)	(48,965,353.80)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	31,794,730.00	30,844,730.00
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(12,642,368.88)	(16,928,754.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,158,502.00	30,849,390.00
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(19,088,881.40)	(13,031,430.16)
39214	Бусад үндсэн хөрөнгө	55,567,755.00	55,567,755.00
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	(10,308,200.07)	(12,984,271.23)
39217	Номын фонд	2,007,285.00	2,007,285.00
39300	Биет бус хөрөнгө	15,314,000.00	15,254,000.00
39301	Програм хангамж	720,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(480,000.00)	(120,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	15,074,000.00	15,074,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	824,038,022.19	806,360,916.72
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	824,038,022.19	806,360,916.72
51	Засгийн газрын хувь оролцоо	824,038,022.19	806,360,916.72
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	60,463,970.50	60,463,970.50
51200	Хуримтлагдсан үр дүн	687,763,845.77	670,086,740.30
51210	Өмнөх үеийн үр дүн	687,763,845.77	687,763,845.77
51220	Тайлант үеийн үр дүн	-	(17,677,105.47)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	75,810,205.92	75,810,205.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	824,038,022.19	806,360,916.72

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	342,398,855.00	286,530,050.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,466,555.00	6,242,750.00
1200	нийтлэг татаварын бус орлого	41,466,555.00	6,242,750.00
120004	төсөө байгууллагын өөрийн орлого	41,466,555.00	-
1200045	үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	41,466,555.00	-
120017	үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Үндсэн хөрөнгө	-	5,360,000.00
120018	үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал	-	882,750.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	300,932,300.00	280,287,300.00
1310	УЛСЫН ТӨСӨӨС	284,361,700.00	265,789,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлээс санхүүжих	284,361,700.00	265,789,800.00
1311	нэмэлт санхүүжилтийн орлого	175,000.00	100,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөөт тусгагдсан төсөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	175,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	100,000.00
1320	Орон нутгийн төсөөс санхүүжих	16,395,600.00	14,397,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт (орон нутгийн төсөөт байгууллага)	16,395,600.00	14,397,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	325,478,340.48	304,207,155.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	325,478,340.48	304,207,155.47
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	294,288,193.54	297,299,109.71
2101	цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	209,649,635.22	204,859,350.00
210101	Үндсэн цалин	171,026,565.22	170,270,162.00
210104	урамшуулал	16,258,897.00	16,035,987.00
210105	Гэрээт ажлын цалин	22,364,173.00	18,553,201.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,571,850.45	27,549,495.02
210201	Тэтгэврийн даатгал	20,238,242.69	17,702,616.00
210202	Тэтгэмжийн даатгал	183,333.00	2,411,631.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,536,233.00	1,989,378.00
210204	Ажилгүйдлийн даатгал	419,853.00	497,461.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,134,188.76	4,947,809.02
2103	Вайр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,218,842.39	16,111,864.22
210301	Гэрэл, цахилгаан	2,136,342.39	2,207,416.22
210302	Тулш, хөлөөлт	9,082,500.00	13,811,648.00
210303	цавэр, бохир ус	-	92,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,746,742.85	5,805,051.43
210401	Бичиг хэрэг	240,500.00	283,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,295,450.00	1,295,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	599,980.00	499,100.00
210405	хөл хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	339,000.00	210,000.00
210406	Бата үнэтэй, түртэн элэгдэх, ахуйн эд зүйлс	885,400.00	790,600.00
210408	Бараа материал өртлөсний зардал	2,386,412.85	2,726,551.43
2105	нормативт зардал	13,349,450.50	10,980,056.00
210501	эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	56,500.00	362,000.00
210502	Хоол, хүнс	12,905,950.50	10,568,056.00
210503	нормын хувцас, зөөлөн эдлэл	387,000.00	50,000.00
2106	Эд хөршил, урсгал засварын зардал	133,400.00	435,800.00
210603	хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	133,400.00	195,800.00
210604	Урсгал засвар	-	240,000.00
2107	Томилолт, зочны зардал	84,000.00	258,000.00
210702	Дотоод албан томилолт	84,000.00	258,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	685,000.00	973,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,000.00	325,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	325,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,849,272.13	30,326,293.04
210902	хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	506,000.00	724,450.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	26,343,272.13	29,601,843.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,190,146.94	6,908,045.76
2134	Орон нутгийн төсвийн өрөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	811,757.61	6,835.78
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	811,757.61	6,835.78
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,018,389.33	5,545,909.98
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,018,389.33	5,545,909.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,360,000.00	1,355,300.00
213209	нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,360,000.00	1,355,300.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	16,920,514.52	(17,677,105.47)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	16,920,514.52	(17,677,105.47)

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	НИЙТ ДҮН
1	ҮЛДЭГДЭЛ	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
8	ҮЛДЭГДЭЛ	60 463 970 50	75 810 205 92	687 763 845 77	824 038 022 19
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	60 463 970 50	75 810 205 92	687 763 845 77	824 038 022 19
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
15	Тайлант үеийн үр дүн	-	-	(17 677 105 47)	(17 677 105 47)
16	ҮЛДЭГДЭЛ	60 463 970 50	75 810 205 92	670 086 740 30	806 360 916 72

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	302,479,353.00	280,287,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,547,053.00	0
120	Нийтлэг татварын бус орлого	1,547,053.00	0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,547,053.00	0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,547,053.00	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	300,932,300.00	280,287,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	284,361,700.00	265,789,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	284,361,700.00	265,789,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	175,000.00	100,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	175,000.00	0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	100,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	16,395,600.00	14,397,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	16,395,600.00	14,397,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	302,479,353.00	280,287,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	302,479,353.00	280,287,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	271,289,206.06	273,379,254.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209,649,636.22	204,869,360.00
210101	Үндсэн цалин	171,026,565.22	170,270,162.00
210104	Урамшуулал	16,258,897.00	16,035,987.00
210105	Гэрээт ажлын хөлс	22,364,173.00	18,553,201.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,571,850.45	27,549,495.02
210201	Тэтгэврийн даатгал	20,238,242.69	17,702,616.00
210202	Тэтгэмжийн даатгал	183,333.00	2,411,631.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,596,233.00	1,989,978.00
210204	Ажилгүйдлийн даатгал	419,853.00	497,461.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,134,188.76	4,947,809.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,583,842.39	12,993,664.22
210301	Гэрэл, цахилгаан	2,136,342.39	2,207,416.22
210302	Түлш, халаалт	13,447,500.00	10,693,448.00
210303	Цэвэр, бохир ус	0	92,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,019,130.00	3,642,700.00
210401	Бичиг хэрэг	275,000.00	249,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,295,450.00	1,295,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	599,980.00	499,100.00
210404	Ном, хэвлэл	150,000.00	150,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	339,000.00	250,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,359,700.00	1,199,300.00
2105	Нормативт зардал	13,361,848.00	14,731,045.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	151,000.00	600,000.00
210502	Хоол, хүнс	12,811,348.00	13,781,045.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	399,500.00	350,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	239,400.00	1,637,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	239,400.00	240,000.00
210604	Урсгал засвар	0	1,397,000.00
2107	Томилолт, зочны зардал	84,000.00	258,000.00
210702	Дотоод албан томилолт	84,000.00	258,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	685,000.00	1,058,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,000.00	410,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	325,000.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,094,500.00	6,649,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,094,500.00	6,649,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,190,146.94	6,908,045.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,360,000.00	1,355,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,360,000.00	1,355,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	811,757.61	6,835.78
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	811,757.61	6,835.78
2136	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,018,389.33	5,545,909.98
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,018,389.33	5,545,909.98

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	280,187,300.0	280,187,300.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	280,187,300.0	280,187,300.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	278,827,300.0	273,379,254.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	205,907,000.0	204,859,350.00
210101	Үндсэн цалин	171,280,100.0	170,270,162.00
210104	Урамшуулал	16,038,400.0	16,035,987.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,588,500.0	18,553,201.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,961,400.0	27,549,495.02
210201	Тэтгэврийн даатгал	18,727,400.0	17,702,616.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,558,000.0	2,411,631.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,047,000.0	1,989,978.00
210204	Ажилгүйдлийн даатгал	511,000.0	497,461.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,118,000.0	4,947,809.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,000,300.0	12,993,664.22
210301	Гэрэл, цахилгаан	2,210,000.0	2,207,416.22
210302	Түлш, халаалт	10,697,500.0	10,693,448.00
210303	Цэвэр, бохир ус	92,800.0	92,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,546,000.0	3,642,700.00
210401	Бичиг хэрэг	250,000.0	249,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,296,000.0	1,295,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	500,000.0	499,100.00
210404	Ном, хэвлэл	150,000.0	150,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.0	250,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,100,000.0	1,199,300.00
2105	Нормативт зардал	17,716,700.0	14,731,045.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	600,000.0	600,000.00
210502	Хоол, хүнс	16,766,700.0	13,781,045.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	350,000.0	350,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,637,200.0	1,637,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	240,000.0	240,000.00
210604	Урсгал засвар	1,397,200.0	1,397,000.00
2107	Томилолт, зочны зардал	350,000.0	258,000.00
210702	Дотоод албан томилолт	350,000.0	258,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,058,700.0	1,058,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	410,700.0	410,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.0	648,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,650,000.0	6,649,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,650,000.0	6,649,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,360,000.0	6,808,045.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,360,000.0	1,355,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,360,000.0	1,355,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	6,835.78
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,835.78
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,445,909.98
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,445,909.98
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	280,187,300.0	280,187,300.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	265,789,800.0	265,789,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	265,789,800.0	265,789,800.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	14,397,500.0	14,397,500.00
132001	Орон нутгийн төсвөөс	14,397,500.0	14,397,500.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны
		Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,545,909.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,545,909.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,545,909.98
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,545,909.98
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,545,909.98
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>100,000.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	100,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	100,000.00

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бигэр сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Аудитын “Улиастай ван аудит” ХХК-ийн аудитор П.Ганцолмон гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Бигэр сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сургуулийн өмнөх боловсролын үндсэн, хувилбарт сургалт зохион байгуулах чиг үүрэгтэй. Хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжсэн таатай орчинд Монгол хүүхдийн онцлогт баримжаалан ирээдүйн иргэнийг төлөвшүүлэх суурийг тавина гэсэн алсын хараатай, Монгол ардын тоглоом наадгай аман зохиолоор дамжуулан мэндлэх хүндлэх ёс, урлан бүтээх чадварыг хөгжүүлж, эрүүл баяр баясгалантай хүүхдийн төлөвшүүлнэ гэсэн эрхэм зорилготой ажилласан.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Харин Засгийн газрын 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахаар даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитаас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бигэр сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 270.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 5.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4.3 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 304.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 6.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4.8 сая төгрөгөөр тооцсон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Бигэр сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2.14 хувиар буюу 17.6 сая төгрөгөөр буурсан байна.

Аудитын код ГАА-2022/121/-НА-СТА-ТШЗ



Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 55.3 сая төгрөг болж 6.6 сая төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал, барилгын засварын материал, хүнсний материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 36.3 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 0.9 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 30.6 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 843.1 сая төгрөг болж 7.6 сая төгрөгөөр буурсан нь 6.2 сая төгрөгийн хөрөнгийг акталсан, 6.8 сая төгрөгийн хөрөнгө данснаас хасаж 5.4 сая төгрөгөөр дахин үнэлсэнтэй холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 806.4 сая төгрөг болж 17.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 16.3 хувиар буюу 83.6 сая төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлоготой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 670.0 сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 363.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 83.2 сая төгрөгөөр бууруулж, 280.2 сая төгрөгөөр баталжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 7 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 280.2 сая төгрөгийн төсөв баталснаас 265.8 сая төгрөгийг улсын төсвөөс 14.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 265.8 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 14.4 сая төгрөг нийт 280.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 274.7 сая төгрөгийг зарцуулж 5.5 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 274.7 сая төгрөг буюу 98 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 1.1 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 1.4 сая төгрөгөөр норматив зардлыг 3.0 сая төгрөгөөр, тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 0.1 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба нэмэлт санхүүжилтийн орлогыг бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс худалдан авах зардалд зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийг орлого, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хууль, НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс 143 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон 4 мэдээлэл, мэдээллээгүй 2 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 212.0 сая төгрөгийн 22 мэдээллээс 212.0 сая төгрөгийн 22 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 3.9.2. НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилт

Худалдан авалтын 4.9 сая төгрөгийн и баримтыг аудитын явцад нөхөн шивүүлсэн. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорил нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах

зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 41.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснээс 41.9 сая төгрөгийн албан шаардлага биелүүлсэн.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар:

1. Бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулах
2. Төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 8.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 5.0 сая төгрөгийн алдаа залруулж, 3.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 заалт бүхий алдаа зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

### 4.1 Залруулсан алдаа

Худалдан авалтын 5.0 сая төгрөгийн и баримтыг аудитын явцад нөхөн шивүүлсэн.


### 4.2 Төлбөрийн акт

Тогтоосон төлбөрийн акт байхгүй.

### 4.3 Албан шаардлага

- Жолоочийн тооцооны хуудсыг журмын дагуу хөтлөөгүй, тооцоо бодоогүй 0.3 сая төгрөгийн шатахуун олгосон нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул албан шаардлага хүргүүллээ.
- Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь: Засгийн газрын 2021 оны "төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар" 43 дугаар тогтоолын 1.1-д "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсвөөс, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал, болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөж хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Татварын хэлтэст 0.13 сая төгрөгийн цалинг дутуу тайлагнасан нь Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 "Суутган төлөгч энэ хуулийн 14 дүгээр зүйл, 16.1.2, 16.1.3, 16.1.4, 17.1.1, 18 дугаар зүйл, 19.1.1, 19.1.2, 20.1-д заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулан суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ." гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Аудитын код ГАА-2022/121/-НА-СТА-ТШЗ



- Тайлант онд 3.3 сая төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Аж ахуй нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэл сууриар хөтөлнө” заалт, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ, 14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2.журналд бичих, 14.3.3.дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.3.4.ажил, гүйлгээний мэдээ гаргах, 14.3.5.санхүүгийн тайлан гаргах. УСНББОУС1, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### 4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн 2.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 1 заалт бүхий зөвлөмж өгч менежментийн захидал тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 212.0 сая төгрөгийн 22 мэдээллээс 212.0 сая төгрөгийн 22 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.
- 1.2. Эрсдэл: Хуулийн хэрэгжилт хангаагүй байх
- 1.3. Өгсөн зөвлөмж: Хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасныг мөрдөж ажиллах
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Бигэр сумын хүүхдийн цэцэрлэг	6	8.8	1	5.0	0	0	4	3.8	1	0